



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/Н1

Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" жил болгон зарлах тухай 07/04 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" жилийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр санал санаачилга гарган ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагийн дарга, төсвийн байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай.

3.Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг ажлын хорооны дарга (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0088

Аймгийн Засаг даргын 2022 оны
 11 дүгээр сарын 11-ны өдрийн
 11 дугаар захирамжийн
 хавсралт

"Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах"
 зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах
 үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Ажил, арга хэмжээ	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр	Хугацаа	Хариуцах байгууллага
1. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ				
1.	Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулна.	-	1 дүгээр сард	Ажлын хороо
2.	"Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах"-жилийн ажлын нээлтийн арга хэмжээг зохион байгуулна.	Аймгийн төсөв	1 дүгээр сард	ХБТХОХ, БОАЖГ
3.	Зорилтот жилийн лого, гарын авлага материалыг хэвлэж, мэдээллийн самбар байршуулна.	Аймгийн төсөв	1 дүгээр сард	ХБТХОХ, БОАЖГ
4.	Сумдын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ болон сумдын зорилтот жилийн ажлын төлөвлөгөөнд тусгуулах ажлын чиглэл хүргүүлж, үр дүнг тооцно.	-	2 дугаар сард	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
5.	Орчны бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар шилдэг ажил өрнүүлсэн сум, байгууллага, аж ахуйн нэгж, айл эрх шалгаруулах болзолт уралдаан зарлаж, дүгнэх, урамшуулал олгоно.	Аймгийн төсөв	Жилдээ	Ажлын хороо
6.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр санал санаачилга гаргасан иргэн, төрийн бус байгууллагуудтай хамтарч аян, бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллана.	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ Сумдын Засаг дарга, Аж ахуйн нэгж
7.	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж, телевиз, радиогийн нэвтрүүлгүүдийг хийнэ.	Аймгийн төсөв	Жилдээ	Аймгийн ЗДТГ, БОАЖГ
8.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" зорилтот жилийн хүрээнд аймгийн зөвлөгөөн зохион байгуулна.	Аймгийн төсөв	2 дугаар сард	ХБТХОХ, БОАЖГ
9.	Зорилтот жилийн хүрээнд сайн туршлага судлах ажлуудыг зохион байгуулна.	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
10.	Ногоон байгууламж, хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд орон нутагт хамааралтай эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	-	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
11.	Ногоон зээлийн сан, Ногоон хэрэм, Ногоон ази, АХБ-ны Япон сан болон	Аймаг, олон улсын төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын



бусад олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч ажиллана.		Засаг дарга		
2. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ				
1.	Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод, бут тарих, мод үржүүлгийн газар байгуулах газрын байршилг тусган батлуулж, аймгийн хэмжээнд 600000 мод, бут тариална.	Аймаг, сум, хувийн хэвшлийн хөрөнгө	Жилдээ	БОАЖГ, холбогдох сумдын Засаг дарга
2.	"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2030 хүртэл хугацаанд мод тарих боломжтой газруудын байршил, судалгааг гаргаж, хэрэгжүүлэх ажлын стратеги, төлөвлөгөө боловсруулж батлуулна.	Аймгийн төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын ЗДТГ
3.	Бүх сумдад соёл амралтын болон цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг зохион байгуулна.	Аймгийн төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын ЗДТГ
4.	Аймагт бүс нутгийн онцлогт тохирсон мод үржүүлгийн газруудыг шинээр байгуулах, өргөтгөх ажлыг зохион байгуулж, энэ чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллана.	Аймгийн төсөв	Жилдээ	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, сумын Засаг дарга
5.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, газар талбайн хуваарь гарган эзэнжүүлэн, гэрээний үр дүнг тооцож ажиллана.	Хувийн хэвшлийн хөрөнгө	1 дүгээр улиралд	БОАЖГ, ХБТХОХ, сумдын Засаг дарга
6.	Төрийн болон хувийн хэвшлийн тариалангийн талбайнуудад хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулж, улсын чанартай автозам дагуу мод тариалах ажлыг эхлүүлнэ.	Аймаг, хувийн хэвшлийн хөрөнгө	1 дүгээр улиралд	ХБТХОХ, БОАЖГ
7.	Мод тарих газрын усалгаа, арчилгаа, хамгаалалтыг хариуцан ажиллах хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэнэ.	Аймгийн төсөв	Жилдээ	Аймгийн ЗДТГ, ХХҮГ, сумдын ЗДТГ
8.	Усалгааны систем, хамгаалалтын хашаа байгуулах технологийн оновчтой шийдлүүдийг нэвтрүүлнэ.	Аймгийн төсөв	2 дугаар улиралд	БОАЖГ
9.	Бордоо, элс, хар шороо, бууц нийлүүлэх ажлыг зохион байгуулна.	Аймгийн төсөв	1, 2 дугаар улиралд	ХБТХОХ, БОАЖГ
10.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сургагч багш бэлтгэн, сургалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, зөвлөмж, гарын авлагыг иргэдэд төрөл бүрийн арга хэлбэрээр хүргэнэ.	Аймаг, сумын төсөв	Жилдээ	БОАЖГ, сумдын Засаг дарга
3. Орчны бохирдлыг бууруулах хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ				
1.	Арвайхээр сумын орчны бохирдлын үнэлгээ хийлгэнэ.	Аймгийн төсөв	1 дүгээр улиралд	ХБТХОХ, БОАЖГ, УЦУОША

2.	Арвайхээр сумын гэр хорооллын айл өрх, төвлөрсөн уурын зуухнуудад шинэ технологи нэвтрүүлж, агаарын бохирдлыг бууруулна.	Улс, аймгийн төсөв	4 дүгээр улиралд	ХБТХОХ, БОАЖГ
3.	Баянтээг түлш ОНӨХХК-ийн тоног төхөөрөмжийг өргөтгөж, сайжруулсан шахмал түлшээр Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхийг бүрэн хангана.	Улс, аймгийн төсөв	3 дугаар улиралд	ХБТХОХ, "Баянтээг түлш" ОНӨХХК
4.	Гэр хорооллын айл өрхүүдийг жишиг загварын ариун цэврийн байгууламжтай болгоно.	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
5.	Малчдыг өвөлжөө, хаваржаа, зусландаа жишиг загварын ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээг зохион байгуулж, хог хаягдлыг сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэх, устгуулах ажлыг хэвшүүлнэ.	-	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
6.	Аялал жуулчлалын маршрутын дагуу болон төв суурингийн нэн шаардлагатай газарт ариун цэврийн байгууламжуудыг шинээр байгуулж, ажиллуулна.	Аймгийн төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ
7.	Бүх сумын төвийн төвлөрсөн хогийн цэгүүдийг хашаажуулан камержуулж, тэдгээрт аюултай хог хаягдлыг устгах цэг ажиллуулж, хог хаягдлын тээвэрлэлтийн горимыг тодорхой болгон мөрдүүлж хэвшүүлнэ.	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
8.	Хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах зориулалт бүхий хогийн савны жишиг загварыг хог хаягдлын нэр, төрлөөр гаргаж, сумдад нэвтрүүлнэ.	Аймгийн төсөв	2 дугаар улиралд	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
9.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд нэвтрүүлж, хог цэвэрлэгээний зориулалтын техник, тоног төхөөрөмжийг сумдад нэвтрүүлнэ.	Аймгийн төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
10.	Аж ахуйн нэгж, байгууллагуудад тогтмол цэвэрлэх нийтийн эзэмшлийн зам, талбайг хуваарилан ногдуулж, тэдэнтэй хог хаягдлын менежментийн чиглэлээр гэрээ байгуулан үр дүнг тооцон ажиллана.	-	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын ЗДТГ
11.	Иргэдийн зөв дадал хэвшилтэй холбоотой сургалт, мэдээлэл, нөлөөллийн цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХБТХОХ, БОАЖГ, сумдын Засаг дарга
12.	Аймгийн хэмжээнд улирал бүр "Бүх нийтийн цэвэрлэгээ"-ний ажил зохион байгуулж, малын сэг зөмийн устгалыг хийж, гол ус, булаг шанд, овоо, давааны хог хаягдлын цэвэрлэгээг хийнэ.	Аймгийн төсөв	Жилдээ	БОАЖГ, ХБТХОХ, сумдын Засаг дарга
13.	Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг бодлогоор дэмжинэ.	Аймгийн төсөв	Жилдээ	ХБТХОХ, ГХБХБГ

14.	Түгийн овооны хогийн цэг хүртэлх 560м газар сайжруулсан зам тавина.	Аймгийн төсөв	Жилдээ	ХБТХОХ, ГХБХБГ
-----	---	---------------	--------	----------------



-00-

Төлөөлөгч Батдахууд

1. Энэтхэг Улсын Хамгаалсан газруудын тухай ашиг зориолын нэгж түүний захирлын сураг дүгнэлт 00 дугаар зүйлийн 50, 1-2, 02 дугаар зүйлийн 00, 1, өдөр хоногийн төсвийн төсөвлөлийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Монгол байгалийн өмчийг хамгаалах Орны Банкныг Бууруулах" жил болгон төрийн үйлдвэр 0704 дугаар кодтойг 2 дугаар хэргийг тус тус үндэслэн ЗАХИРАЛГААР нь...

1. Монгол байгалийн өмчийг хамгаалах Орны Банкныг Бууруулах жил болгон төрийн үйлдвэр 0704 дугаар кодтойг 2 дугаар хэргийг тус тус үндэслэн...

2. Төлөөлөгчид үйлдвэрлэл эрх, хамгаалалтын харилцааг үндсэн болгохын зорилгоор төрийн үйлдвэр 0704 дугаар кодтойг 2 дугаар хэргийг тус тус үндэслэн...

3. Энэтхэг Улсын Хамгаалсан газруудын тухай ашиг зориолын нэгж түүний захирлын сураг дүгнэлт 00 дугаар зүйлийн 50, 1-2, 02 дугаар зүйлийн 00, 1, өдөр хоногийн төсвийн төсөвлөлийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн...

ЗАСАГ ДУРГА

(Handwritten signature)

А.ИМДӨРЖ